


АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМӨНХ



БАТЛАВ
БӨМБӨӨЖИГ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ М.АРИУНБОЛД



ЦАЙНЫ ГАЗРЫГ ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 107/2022

2022 оны 09 сарын 15

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх /цаашид түрээслүүлэгч гэх/нөгөө талаас Бөмбөөжиг ХХК-ийн захирал М.Ариунболд /цаашид түрээслэгч гэх /хамтад нь/ цаашид талууд гэх /нар нь Монгол улсын иргэний хуулийн 318-326 дугаар зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дахь заалт, Хүнсний тухай хууль болон холбогдох журам, дүрмийг мөрдлөг болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Талууд харилцан зөвшилцөж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээн цайны газрын тоног төхөөрөмж, эд хогшил, байр 55м² /тавин тав / талбайтай Улаанбаатар хотын БЗД-н 8-р хороо, Ус-15-1-1 хаягт байрлах Амгалан дулааны станц ТӨХК-ийн цайны газрыг зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулах зорилгоор ашиглуулахаар шилжүүлж, Түрээслэгч гэрээнд заасан түрээсийн төлбөрийг тогтоосон хугацаанд саадгүй төлөх, талуудаас байрыг түрээсээр эзэмших, эзэмшүүлэх, ажилтнуудыг эрүүл ахуйн стандартад нийцсэн, чанарын шаардлага хангасан илчлэг, чанартай эрүүл хоолоор үйлчлэхэд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Талууд 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн түрээсийн төлбөрийг тооцно.
- 1.3 Түрээсийн байрыг талууд актаар хүлээлцэнэ. Гэрээний хавсралт №1-т заасан тоног төхөөрөмж, эд хөрөнгө, хавсралт №2-т заасан сарын төлбөрийн хуваарь болон бусад дагалдах баримт бичигүүд болно.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Гэрээний хугацаа 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 2.2. Гэрээг талууд улирлаар дүгнэнэ.

Гурав. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

- 3.1. Түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг шаардах, төлүүлэх.
- 3.2. Түрээслүүлэгч нь түрээслүүлсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, түрээсийн төлбөр төлөлтийн талаар гарсан зөрчлийг арилгуулахаар шаардлага тавих эрхтэй.
- 3.3. Түрээсийн байрны халуун, хүйтэн ус, халаалт, цахилгаан болон холбогдох бусад нөхцлөөр тасралтгүй хангах.
- 3.4. Түрээслүүлэгч талаас хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн стандарт чанарт тогтмол хяналт тавьж ажиллана.
- 3.5. Түрээслэгчийн гэм буруутай үйл ажиллагааны улмаас түрээсийн байрны шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарвал түрээслэгчээс тухайн эвдрэлийг засахыг шаардах эсвэл түрээслүүлэгч тал өөрийн хөрөнгөөр засварлаж, төлбөрийг нэхэмжлэх эрхтэй.
- 3.6. Түрээслэгчээс эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар гаргасан санал, санаачлага түүнийгээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж ажиллах үүрэгтэй.
- 3.7. Түрээслүүлсэн эд хөрөнгөд түрээслэгчийн үйл ажиллагаанаас үл шалтгаалсан осол, гэмтэл гарвал түүний үр дагаврыг арилгах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг нэн даруй авах үүрэгтэй.
- 3.8. Түрээслүүлэгч түрээслүүлж буй эд хөрөнгийг түрээслэгчид актаар хүлээлгэн өгч, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр бүрэн хангах үүрэгтэй.
- 3.9. Түрээсийн төлбөрийн хэмжээг тогтвортой байлгах, ажилтнуудын хоолны төлбөрийг сар бүрийн 5-ны /тав/ дотор түрээслэгчийн Хаан банкны 5753047912 тоот дансанд шилжүүлднэ.
- 3.10. Түрээслүүлэгч нь түрээслүүлж буй объектын инженерийн шугам сүлжээний их, урсгал засварыг хариуцна.

Дөрөв: Түрээслэгчийн эрх, үүрэг

- 4.1. Түрээслэгч тал түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр энэхүү байрыг гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд бусдад түрээслэх, барьцаалах эрхгүй.
- 4.2. Түрээслэгч нь цахилгаан, дулаан, цэвэр бохир усаар тасралтгүй хангуулах, хангаагүйгээс гарсан зөрчлийг цаг тухайд нь арилгуулах эрхтэй.
- 4.3. Түрээсийн байрны бүхий л эд зүйлс, өрөө тасалгаануудыг зориулалтын дагуу ариг гамтай, цэвэр үзэмжтэй бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд түрээслэгчийн хариуцлагагүйгээс түрээсийн эд зүйлс хулгайд алдагдах, эвдэрч гэмтэх зэргээс үүдэлтэй хохирлыг бүрэн хариуцна.

- 4.4. Түрээслэгч нь түрээсийн байрны галын аюулгүй байдлыг хангаж, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах үүрэгтэй, мөн цэвэр, бохир усны шугам сүлжээ, цахилгааны аюулгүй байдлыг хангаж ажиллах ба өөрсдийн буруугаас зөрчил гаргасан бол гарсан хохирол болон хариуцлагаа бүрэн хүлээнэ.
- 4.5. Түрээсийн байрны болон тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн үйлчилгээний зардлыг бүрэн хариуцна.
- 4.6. Түрээслэгч нь Монгол Улсын MNS-4946:2005 стандартын дагуу хоолны газрын ангилал, зэрэглэл, стандартын шаардлагуудыг хангаж, эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрмийн заалтуудыг (МХЕГ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/179 тоот тушаалаар батлагдсан) мөрдөж ажиллах үүрэгтэй. Түрээслэгч нь халуун хоол, зууш, ундааны зүйл үйлдвэрлэхдээ нэр төрлийн өргөн сонголттой, амт чанар, илчлэг нь Монгол Улсын стандарт шаардлагад нийцсэн, үндэсний уламжлалт болон эмчилгээний хоол сонгох боломжоор хангагдсан, өдрийн хоол нь ээлжийн /орой/ хоолноос өөр нэр төрөлтэй хагас, бүтэн порцтой байх бөгөөд Монгол Улсын нийтийн хоолны орчин үеийн жор технологийг ашиглах үүрэгтэй. Түрээслүүлэгчийн саналаар хоолны өдөр тутмын цэсийг харилцан тохирч тодорхой хугацаагаар тогтоож өгч болно.
- 4.7. Түрээслэгч нь өдөр бүрийн хоолны дээжийг авч зориулалтын хөргөгчинд хийж тэмдэглэл хөтлөх ба улиралдаа 1/нэг/ удаа зөвшөөрөгдсөн лабораторид хоолны дээжийг шинжлүүлж дүгнэлтийг түрээслүүлэгч талд танилцуулж байх үүрэгтэй. Мөн түрээслэгч нь ЭМСайдын 2017 оны А/145-р тушаалын 2.1-д зааснаар хоолны газрын ажиллагсдыг 6 сар тутамд арьсны халдварт өвчнүүд, жилд 1 удаа сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байх.
- 4.8. Түрээслэгч нь хоолны үйлдвэрлэлд ашиглах хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ, бүтээгдэхүүнийг гарал үүслийн бичигтэй, баталгаатай, эрүүл ахуйн шаардлага хангасан бөөний төв, аж ахуйн нэгж байгууллагаас авч хоолны үйлдвэрлэлийг явуулах үүрэгтэй.
- 4.9. Хоолны үнэ, нэр төрлийг жагсаалтаар баталж түрээслүүлэгчид өгөх, мөн хоолны нэр төрлийг хагас бүтэн порцоор гаргах бөгөөд үнийг тогтвортой мөрдөж ажиллах, хоолны гол нэр төрлийн бүтээгдэхүүн /мах, ногоо, гурил/-ны үнэд өөрчлөт орж, хоолны үнийг зайлшгүй өөрчлөх болсон тохиолдолд түрээслүүлэгч талд албан ёсоор мэдэгдэж, хоёр тал харилцан зөвшилцөж шийдвэрлэх үүрэгтэй.
- 4.10. Түрээслэгч нь ажилтнуудад түргэн шуурхай, соёлч боловсон үйлчилж, зан харилцааны доголдол гаргахгүй ажиллах үүрэгтэй.

- 4.11. Үйлдвэрлэж буй хоол хүнс нь эрүүл ахуйн шаардлага, стандарт, хүнсний аюулгүй байдлыг хангаагүйн улмаас ажилтнууд хоолны хордлого, халдварт өвчинд өртсөн нь Нийслэлийн болон дүүргийн мэргэжлийн байгууллагын шинжилгээгээр тогтоогдсон тохиолдолд хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцлага хүлээж ажилтнуудад учирсан хохирлыг бүрэн барагдуулах үүрэг хүлээнэ.
- 4.12. Аливаа зөвшилцөл, шийдвэр, асуудал бүрийг бичгийн хэлбэрээр үйлдэж баталгаажуулна.
- 4.13. Түрээсийн гэрээ дуусгавар болсон, гэрээ цуцлагдсан тохиолдолд хийгдээгүй ашиглалтын зардлын төлбөр тооцоог бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
- 4.14. Цайны газраас гарсан хог хаягдлыг түрээслэгч бүрэн хариуцаж өдөр бүр цэвэрлэж ачуулна./Хоолны хог хаягдлыг удаан хугацаанд хадгалах, агаар орчныг бохирдуулахыг хатуу хориглоно/.
- 4.15. Орчны талбайг хуульд заасан хэмжээгээр буюу 50 метр орчныг, дотор талбайд цайны газрын орох хэсгийн нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэнэ.
- 4.16. Түрээслэгч нь цайны газрын ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, осол зөрчилгүй ажиллуулах үүрэгтэй бөгөөд хэрэв осол, зөрчил гаргасан тохиолдолд хохирол болон хариуцлагыг бүрэн хүлээнэ.
- 4.17. Түрээслэгч нь цайны газрын ажилтнуудаа ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, тогтмол зөв хэрэглүүлж ажиллуулах үүрэгтэй.
- 4.18. Түрээслэгч байгууллагын ажилтнууд нь ажиллах хугацаандаа түрээслүүлэгч байгууллагын дотоод журам, харуул хамгаалалтын дүрэм журмыг чанд мөрдөж ажиллана.
- 4.19. Нийтээр тэмдэглэх баярын өдөр, тэмдэглэлт болон амралтын өдрүүдээр хуваарийн дагуу ажиллах.
- 4.20. Оройн ээлжинд ажиллаж байгаа ажилтнуудад хуваарийн дагуу цайны газраар үйлчлэх.

Тав. Түрээсийн болон бусад төлбөр, тооцоо

- 5.1. Түрээсээр ашиглаж буй үл хөдлөх хөрөнгийн болон үндсэн хэсгийн талбайн түрээсийн төлбөрийг тус гэрээний хавсралтад заасан хэмжээ, хуваарийн дагуу сар бүрийн 30-ны дотор Түрээслүүлэгчийн дансанд төлнө. Түрээсийн төлбөр төлөх:
Банкны нэр: Капитрон Банк
Дансны дугаар: 3004012002
Нэг сарын төлбөр: 550,000 /таван зуун тавин мянга/-н төгрөг
Жилийн нийт төлбөр: 5,280,000 /таван сая хоёр зуун наян мянга/-н төгрөг байна.

- 5.2. Хоолны материалын зах зээлийн үнэ нэмэгдэж, хоолны үнэ нэмэгдэх зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд хоолны үнийг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 5.3. Түрээслэгч нь ажилтнуудад олгох хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнийг норм хуваарийн дагуу олгож үйлчилнэ.

Зургаа.Хориглох зүйл болон нэмэлт тохиролцоо

- 6.1. Түрээслэгчид хориглох зүйл:
 - 6.1.1.Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр байрыг зориулалтын бусаар ашиглах.
 - 6.1.2.Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх, давхар түрээслүүлэх.
 - 6.1.3.Ажлын байранд архи, тамхи, мансууруулах бодис зарах, хэрэглэх, орчны амгалан тайван байдлыг алдагдуулах аливаа үйлдэл, хэрүүл шуугиан үүсгэхгүй байх.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, тахал болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт импортын хориг, ажил хаялт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
 - 7.1.1.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас түрээслүүлсэн эд хөрөнгийн чанар байдал алдагдвал талууд харилцан тохиролцож мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийг үндэслэн түрээсийн төлбөрийг өөрчилж болно.
 - 7.1.2.Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй бичгээр мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдана.

Найм. Талуудын хариуцлага

- 8.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсвэл хэсэгчлэн биелүүлсэн тохиолдолд дараахь хариуцлага хүлээнэ. Үүнд:
 - 8.1.1.Түрээслэгч нь түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу хугацаандаа бүрэн төлөөгүй хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 хувийн алданги төлнө.
 - 8.1.2.Түрээслүүлэгч нь ажилтнуудын хоолны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөөгүй бол гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0,1 хувиар тооцож алданги төлнө.

- 8.1.3. Гэрээнд заасан хугацаа дуусгавар болсон, гэрээ цуцлагдсан тохиолдолд түрээсийн байр, эд хөрөнгийг үрэгдүүлсэн болон эвдэж гэмтээсэн тохиолдолд тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцож төлбөрийг барагдуулна.
- 8.1.4. Үйлдвэрлэж буй хоол хүнс нь эрүүл ахуйн шаардлага, стандарт, хүнсний аюулгүй байдлыг хангахгүйн улмаас хоолны хордлого, халдварт өвчин гарсан тохиолдолд үүнээс үүдэн гарсан хохирлыг түрээслэгч тал бүрэн хариуцна.
- 8.1.5. Гэрээг цуцлах тухай саналаа аль нэг тал нөгөө талдаа нэг сарын өмнө бичгээр ирүүлнэ
- 8.1.6. Түрээслүүлэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Аж ахуйн ажилтан С.Болд хариуцан ажиллана. Утас-99095047
- 8.1.7. Түрээслэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг “Бөмбөөжиг” ХХК-ийн захирал М.Ариунболд хариуцан ажиллана. Утас-99296498

Ес. Гэрээг хугацаанаас өмнө цуцлах үндэслэл


- 9.1. Түрээслэгч тал түрээсийн төлбөрөө хоёр сар хүртэл хугацаагаар хожимдуулах, эд хөрөнгийн ашиглалт үйлчилгээний шаардлагыг хангахгүй байх болон түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр дамжуулан түрээслэх, барьцаалах, зориулалтыг дур мэдэн өөрчлөх, эвдэж гэмтээх зэрэг зөрчил гаргасан тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах. Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн хэмжээг үндэслэлгүйгээр нэмэх, ажилтнуудын хоолны төлбөрийг төлөх хугацааг хоёр сар хүртэлх хугацаагаар хэтрүүлэх, гэрээний бус шаардлага тавих, дарамт шахалт үзүүлсэн бол түрээслэгч тал гэрээ цуцлах.
- 9.2. Түрээслэгчийн үйлдвэрлэж буй хоол нь эрүүл ахуйн шаардлага, стандарт, хүнсний аюулгүй байдлыг хангаагүйн улмаас ажилтнуудаас /нэг ба түүнээс дээш ажилтан/ хоолны хордлого, халдварт өвчинд өртсөн нь Нийслэлийн болон дүүргийн мэргэжлийн байгууллагын шинжилгээгээр тогтоогдсон бол түрээслүүлэгч гэрээг дангаар цуцлах эрхтэй. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3. Түрээслэгч гэрээгээр тохиролцсон хоолны үнийг үндэслэлгүйгээр нэмсэн, хоолны амт чанарын талаар удаа дараа ажилтнуудаас гомдол гаргасны мөрөөр сайжруулах арга хэмжээ аваагүй зэрэг зөрчлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн бол түрээслүүлэгч гэрээг дангаар цуцлах эрхтэй.


Арав. Хууль хэрэглэх, маргаан шийдвэрлэх


- 10.1. Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийг үндэслэн хийгдсэн бөгөөд түүний дагуу зохицуулагдана. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээний заалтыг нэн тэргүүнд баримтална.
- 10.2. Гэрээний үүргийн биелэлтийн явцад гарсан маргааныг талууд харилцан зөвшилцөж хэлэлцээр хийх замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ. Зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.


Арван нэг. Бусад зүйл


- 11.1. Энэхүү гэрээг 3 хувь үйлдсэн бөгөөд хувь тус бүр нь ижил хүчинтэй байна. Талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хучин төгөлдөр болж тухайн өдрөөс мөрдөгдөнө.
- 11.2. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй. Нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа аль нэг тал нөгөө талдаа нэг сарын өмнө бичгээр ирүүлнэ. Нэмэлт өөрчлөлтийг бичгээр хийх бөгөөд талууд гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Гэрээний нэмэлт өөрчлөлт энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 11.3. Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, албан захидлууд нь бичгийн хэлбэрээр хийгдэх бөгөөд доорх хаягаар хүргэсэн үед хүлээн авсан гарын үсэг зурагдсанаар тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.
- 11.4. Гэрээний хавсралтад түрээслэгч аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар, түрээслүүлэгчээс түрээслэгчид хүлээлгэн өгсөн үндсэн хөрөнгө, эд аж ахуйн жагсаалт, түрээслэгчийн хоолны нэр, төрөл үнийн жагсаалтыг тус тус хавсаргах бөгөөд эдгээр хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТОЛООЛЖ:
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
СЭЭХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ
Ө.УДВАЛ
Гарын үсэг: 


ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
П.ЗОРИГОО
Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ЭРДЭНЭБИЛЭГ
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ
Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш.АМИНЖАРГАЛ
Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх
дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТОЛООЛЖ:
“БӨМБӨӨЖИГ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
М.АРИУНБОЛД
Гарын үсэг: 



Хаяг: Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Ботаникийн
эцэст 2-27
Утас: 99296498
РД: 2868946